



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 44

Эрдэнэт

Комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.11 дэх заалт, Хууль зүйн сайдын 2014 оны А/89 дүгээр тушаалаар батлагдсан "Иргэний Зөвлөлийн дүрэм"-ийн 3.2-т заасныг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий иргэний төлөөллөөс бүрдсэн орон тооны бус Иргэний зөвлөлийн зарим гишүүнийг сонгон шалгаруулах комиссыг хавсралтын ёсоор байгуулсугай.

2.Сонгон шалгаруулалтыг холбогдох хууль, дүрэмд заасны дагуу зохион байгуулж дүнг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэхийг сонгон шалгаруулах комисст даалгасугай.

ДАРГА



П.ПҮРЭВЛХАГВА